



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/242

Улиастай

Тусгай зөвшөөрөл сунгаж,
олгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.7, 14 дүгээр зүйлийн 14.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 59, 2014 оны 18 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, сумдын Засаг даргын саналыг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг сунган, нэрсийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Иргэд, аж ахуйн нэгжийн ирүүлсэн өргөдөл хүсэлт, сумдын Засаг дарга нарын саналыг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг шинээр олгон, нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Зөвшөөрөгдсөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу тогтмол хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /А.Даваадорж/, Цагдаагийн газар /С.Цэрэнсамбуу/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТСАЙХАН



